



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дижитал өгөгдөл дата төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 70533552 Цахим хаяг: Болормааја@audit.gov.mn

Аудитор: П.Санчиргарав

Утас: 70533552 Цахим хаяг: Sanchirgaravp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланаадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: omnogovi@audit.gov.mn

2026.08.16 № 306
таныг _____ -ны № _____ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДИЖИТАЛ
ӨГӨГДӨЛ ДАТА ТӨВ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.ЧИНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дижитал өгөгдөл дата төв" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй цалингийн нэмэгдэл олгосон, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зэрэг нийт 69,944.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/05 дугаар тогтоолыг үндэслэн 2,627,923.8 мянган төгрөгийн хөрөнгөтэй үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

FIQ Бичиг баримт: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДИЖИТАЛ ӨГӨГДӨЛ ДАТА ТӨВ

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны бизнес төлөвлөгөөнд нийт орлогыг 964,090.9 мянга, нийт зардлыг 959,585.1 мянган төгрөг байхаар баталж, гүйцэтгэлээр 556,902.9 мянган төгрөгөөр орлого бүрдүүлэн 437,456.0 мянган төгрөг зарцуулж, орлогын төлөвлөгөө 57.8 хувьтай биелсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Орон нутгийн төсвөөс 18,479.5 мянган төгрөгийн нутгийн дэмийн урамшуулал олгосон байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхлэлтийн баланс	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		144,749,686.08
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		-
1.1.6	Бараа материал		12,325,480.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		157,075,166.08
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,530,186,167.00	2,800,704,404.98
1.2.2	Биет бус хөрөнгө	97,737,675.00	116,637,675.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,627,923,842.00	2,917,342,079.98
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,627,923,842.00	3,074,417,246.06
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		-
2.1.1.3	Татварын өр		13,690,073.89
2.1.1.4	НДШ-ийн өглөг		-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		13,690,073.89
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		309,803,781
2.1.2.1	Бусад урт хугацаат өглөг		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		309,803,781
2.2	Өр төлбөрийн нийт дүн		323,493,854.89
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	2,627,923,842.00	2,627,923,842.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		-
2.3.9	Хуримтлагдсан ашиг		122,999,549.17
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,627,923,842.00	2,750,923,391.17
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,627,923,842.00	3,074,417,246.06

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Балансын зүйл	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	557,717,088.77
2	Борлуулалтын өртөг	419,631,168.02
3	Нийт ашиг(алдагдал)	138,085,920.75
4	Түрээсийн орлого	-
5	Хүүгийн орлого	759,168.77
6	Ногдол ашгийн орлого	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-
8	Бусад орлого	18,479,545.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	19,899,300.00
11	Санхүүгийн зардал	-
12	Бусад зардал	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-
17	Бусад ашиг (алдагдал)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	136,666,165.75
19	Орлогын татварын зардал	13,666,616.58
20	Татварын дараах ашиг (алдагдал)	122,999,549.18
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	122,999,549.18
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-
24	Орлогын нийт дүн	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2025 оны 06 сарын 30-аар үлдэгдэл	2,627,923,842.00		2,627,923,842.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	122,999,549.10	122,999,549.10
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	2,627,923,842.00	122,999,549.10	2,750,923,391.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	576,196,633.77
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	576,196,633.77
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	241,199,203.77
1.2.1	Ажиллагчдад төлсөн	182,368,278.73
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	58,830,925.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	216,785,499.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-
2.1.8	Бусад	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-
2.2.6	Бусад	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	72,035,813.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	72,035,813.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-
3.1.4	Бусад	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(72,035,813.00)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-
3.2.5	Бусад	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	144,749,686.08
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	144,749,686.08

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 352,320.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад 352,320.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 339,486.3 мянган төгрөгийн зардлын тусгаагүй;
- Орлогын дэлгэрэнгүй тайланг, аж ахуйн нэгжийн орлогын тайлангаас 118,199.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Аудитаар 3,305,909.5 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 677,985.7 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 2,627,923.8 мянган төгрөгийн хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт:1 Аймгийн Засаг даргын захирамжид цалингийн нэмэгдлийг тодорхой заагаагүй байхад байгууллагын дарга өөртөө 7,800.0 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д "Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:2 "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгаагүй 12,834.0 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг даргын тушаалаар олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д "Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:3 Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 17,822.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 27,687.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: 4 Эхлэлтийн балансын эзний өмчийг 2,627,923.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.

Энэ нь Төвийн тухай хуулийн "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.4-д "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03/05 дугаар "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулах тухай" тогтоолын хавсралтаар баталсан "Дижитал өгөгдөл дата төв ОНӨААТҮГ-ын дүрэм" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

3.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй Орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 339,486.3 төгрөгийн зардлын тусгаагүй	1	339,486.3			1	339,486.3	1	339,486.3				
2	Орлогын дэлгэрэнгүй тайланг, аж ахуйн нэгжийн орлогын тайлангаас 118,199.9 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	12,834.1			1	12,834.1	1	12,834.1				
	Дүн	2	352,320.4			2	352,320.4	2	352,320.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д · Д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Аймгийн Засаг даргын захирамжид цалингийн нэмэгдлийг тодорхой заагаагүй байхад байгууллагын дарга өөртөө 7,800.0 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг олгосон	1	7,800.0			1	7,800.0						
2	"Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгаагүй 12,834.0 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг даргын тушаалаар олгосон	1	12,834.1			1	12,834.1						
3	Татварын авлага 1,975.0 мянган төгрөг, өглөг 1,925.6 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	3,900.7			1	3,900.7						
4	Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 17,822.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 27,687.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй	1	45,410.1			1	45,410.1						
5	Эхлэлтийн балансын эзний өмчийг 2,627,923.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй.	1	2,627,923.8							1	2,627,923.8		
	Дүн	5	3,305,909.5			4	677,985.7			1	2,627,923.8		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг https://shilendans.gov.mn/ сайтад байршуулсан мэдээлэлтэй тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 46,811.3 мянган төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээ, 561,229.4 мянган төгрөгийн 7 орлогын гүйлгээг мэдээлээгүй, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлд мэдээлэл, 9 дүгээр сарын мэдээллийг оруулаагүй	1	608,040.7	-	-	-	-	1	608,040.7
Дүн	1	608,040.7	-	-	-	-	1	608,040.7